



ТӨРИЙН ӨМЧИЙН 6 ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛУУДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар *А/220, А/352, А/245* Улаанбаатар хот
А/220, А/304, А/188.

Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах журам батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21, 8.1.24, 44 дүгээр зүйлийн 44.1.2, 44.1.6 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт, 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичгийн 3.3 дахь заалт, тус санамж бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.37, Төрийн өмчийн 6 их сургуулийн захирлуудын хамтарсан 2021 оны А/158, А/193, А/127, А/146, А/145, А/175 дугаар тушаалын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Төрийн өмчийн их сургуулиудын багш, ажилтан, албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үед баримтлах журмыг хавсралтаар баталсугай.

2.Төрийн өмчийн их сургуулиудын багш, ажилтан, албан хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг хуваарийн дагуу чанартай зохион байгуулахыг АШУУИС-ийн Эмнэлэг хариуцсан дэд захирал (Д.Цэрэндавга)-д үүрэг болгосугай.

3.Эрдэмтэн багш, ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жигд, хүртээмжтэй хамруулах, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад шаардлагатай эмнэлгийн үйлчилгээний зардлыг жил бүрийн төсөвт тусгах санал оруулж, шийдвэрлүүлэн ажиллахыг төрийн өмчийн их сургуулиудын тухайн асуудал хариуцсан дэд захирал, газар, албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төрийн өмчийн 6 их сургуулиудын тухайн асуудал хариуцсан дэд захирлуудад даалгасугай.

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Н.ХҮРЭЛБААТАР



ХӨДӨӨ АЖ АХУЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Т.ХЭРҮҮГА



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Б.ОЧИРБАТ




МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Б.ОЧИРХУЯГ




МОНГОЛ УЛСЫН БАГШИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ДЭД ПРОФЕССОР О.АЛТАНГОО



СОЁЛ УРЛАГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
ПРОФЕССОР Э.СОНИНТОГОС






УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь төрийн өмчийн их сургуулиудын багш, ажилтан, албан хаагчдыг АШУҮИС-ийн харьяа эмнэлгүүдийн Эрүүл мэндийг дэмжих төвийн (цаашид “ЭМДТ” гэх) урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Урьдчилан сэргийлэх үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцна.
- 1.3. Урьдчилан сэргийлэх үзлэгийн багцад тусгагдаагүй хийлгэх хүсэлтэй шинжилгээний төлбөрийг АШУҮИС-ийн харьяа тухайн эмнэлгийн төлбөртэй тусламж, үйлчилгээний үнэ, тарифаар тооцон ажилтан төлнө.
- 1.4. Урьдчилан сэргийлэх үзлэгийн багц, үнэ тариф болон үзлэг зохион байгуулах хуваарийг АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталж жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сургуулиудад хүргүүлнэ.

Хоёр. Урьдчилан сэргийлэх үзлэгийн зохион байгуулалт

- 2.1. Урьдчилан сэргийлэх үзлэгийн нэг дэх өдөр:
 - 2.1.1. Эрүүл мэндийг дэмжих төвд хуваарьт заасан цагаас хоцролгүй ирэх;
 - 2.1.2. Бүртгэлийн ажилтанд хандаж урьдчилан сэргийлэх үзлэгийн багц идэвхжүүлэх;
 - 2.1.3. ЭМДТ-ийн сувилагч амин үзүүлэлт хэмжиж, цус, шээсний шинжилгээ, зүрхний цахилгаан бичлэг хийх;
 - 2.1.4. ЭМДТ-д хэвлийн ЭХО шинжилгээ хийлгэх;
 - 2.1.5. Эмнэлгийн хоёрдугаар давхарт цээжний рентген шинжилгээ хийлгэнэ.
- 2.2. Урьдчилан сэргийлэх үзлэгийн хоёр дахь өдөр:
 - 2.2.1. Үйлчлүүлэгчийн шинжилгээний хариуг дотрын эмч нэгтгэн тухайн багш, ажилтан, албан хаагчид зөвлөгөө өгөх;
 - 2.2.2. Үйлчлүүлэгчийн шинжилгээний хариу ноцтой өөрчлөлттэй гарсан тохиолдолд зөвлөх эмчид илгээж дотрын эмч нэмэлт чиглүүлэг, зөвлөгөө авах;
 - 2.2.3. Хуваарьт заасан цагаас хоцролгүй ирж эмчийн үзлэгт хамрагдана.
- 2.3. Багцад тусгагдаагүй, нэмэлтээр хийлгэх хүсэлтэй үзлэг, оношилгоонд хамрагдах:
 - 2.3.1. Утсаар болон цахимаар холбогдон цаг авах /цаг товлох зохицуулалтыг жич хүргүүлэх/;
 - 2.3.2. Товлосон цагаас 30 минутын өмнө ирж төлбөрөө төлж, бүртгэл мэдээллийн ажилтнаас цаг баталгаажуулсан хуудас авах;
 - 2.3.3. Үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдана.
- 2.4. Тухайн байгууллагад үзлэгийн нэгдсэн тайланг үзлэг зохион байгуулсан өдрөөс хойш 1 сарын дотор тайланг хүргүүлнэ.



Гурав. Халдвар хамгааллын дэглэм


- 3.1. Эмнэлэг халдварын эрсдэлтэй бүс тул ЭМДТ-ийн ажилтны чиглүүлснээс өөр байршлуудаар явахгүй байх, дуугүй хөтөч, тэмдэглэгээ, сануулгыг анхаарах;
- 3.2. Эмнэлгийн орчинд амны хаалтыг эмчийн хүсэлтээс бусад үед авахгүй байх;
- 3.3. Нэг удаагийн амны хаалтыг 2 цаг тутамд солих;
- 3.4. Спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэгч өөрийн биед авч явах, гараа тогтмол халдваргүйжүүлэх;
- 3.5. Хүн хоорондын зай барих, үзлэг тус бүрд нэрсийн дарааллаар дуудах тул дугаарлан зогсохгүй байх;
- 3.6. Давхар хооронд зорчихдоо шилэн лифт болон түүний хажуугийн шатыг ашиглах;
- 3.7. Үйлчлүүлэгч нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ийн ойрын хавьтал болсон, шинж тэмдэг илэрсэн, халдвар илэрсэн гэх мэт эрсдэл үүсэх тохиолдолд эмнэлгээр үйлчлүүлэхгүй байх, үйлчлүүлэх боломжгүй болсон тухай ЭМДТ-д болон өөрийн байгууллагын үзлэг зохион байгуулж буй ажилтанд урьдчилан мэдэгдэнэ.

Дөрөв. Үйлчлүүлэгчийн эрх


- 4.1. Үйлчлүүлэгч нь эрүүл мэндийн чанартай, тэгш хүртээмжтэй тусламж, үйлчилгээг авах;
- 4.2. Биеийн эрүүл мэндийн байдал болон эмчилгээ, үйлчилгээний үр дүн, өвчний явц, цаашид хийх эмчилгээ, гарч болох үр дагаврын талаар мэдээлэл авч, эмнэлгийн мэргэжилтэнтэй харилцан ярилцах, тайлбар авах;
- 4.3. Өөрийн эрүүл мэндийн талаарх нууцаа хамгаалуулах;
- 4.4. Олон улсын хөл хориот, байгалийн голомтот болон бусдын эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй халдварт өвчтэй, сэтгэцийн хувьд өөрийгөө хянах чадваргүй болсноос бусад тохиолдолд эмнэлгийн мэргэжилтний зөвлөсөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авахаас татгалзах;
- 4.5. Хүний эрүүл мэндэд харш, үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэний талаар холбогдох байгууллагад мэдээлэх, өргөдөл, гомдол гаргах;
- 4.6. Анагаахын болон шинжлэх ухааны судалгаа болон туршилтад оролцохоос татгалзах эрхтэй.

Тав. Үйлчлүүлэгчийн үүрэг

- 5.1. Үйлчлүүлэгч өөрийнхөө болон гэр бүлийнхээ эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх;
- 5.2. Эрүүл мэнддээ анхаарах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх дадал эзэмших;
- 5.3. Эрүүл мэндийн байгууллагын ажилтантай хүндэтгэлтэй харилцаж, соёлтой үйлчлүүлэх;
- 5.4. Байгууллагын дотоод, дүрэм, журмыг дагаж мөрдөх;
- 5.5. Өөрийн болон асран хамгаалж буй үйлчлүүлэгчийн биеийн эрүүл мэндийн талаарх мэдээллээ эмнэлгийн мэргэжилтэнд үнэн зөв, бүрэн мэдээлэх;
- 5.6. Эмчилгээ, үйлчилгээний заавар дэглэмийг чанд сахих;
- 5.7. Эмчилгээ, үйлчилгээний заавар дэглэмийг мөрдөхөөс татгалзаж байгаа бол бичгээр баталгаажуулах;
- 5.8. Хууль, журмаар зөвшөөрөгдсөн төлбөртэй тусламж, үйлчилгээ авсан бол үйлчилгээний төлбөрийг төлөх;



- 5.9. Бусдын эрхийг хүндэтгэх;
- 5.10. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байхад зураг авах болон дуу, дүрс бичлэг хийхгүй байх үүрэгтэй.



Зургаа. Шинжилгээнд бэлтгэх

- 6.1. Цусны шинжилгээнд бэлтгэх:
 - 6.1.1. Өлөн буюу бага хэмжээний ус уусан байх;
 - 6.1.2. Шинжилгээ өгөхийн өмнө тайван байх;
 - 6.1.3. Эм, тариа, антибиотик хэрэглээгүй байх /3 хоногийн өмнөөс/;
 - 6.1.4. Өөх тостой, халуун ногоотой, хуурсан хоол хэрэглээгүй байх /3 хоногийн өмнөөс/;
 - 6.1.5. Согтууруулах ундаа хэрэглээгүй байх /3 хоногийн өмнөөс/;
 - 6.1.6. Бусад багажийн шинжилгээнээс өмнө өгөх. Жишээ нь: ЭХО, рентген, MRI, CT;
 - 6.1.7. Сахар, өөх тос, нойр булчирхайн үйл ажиллагааг үнэлэх шинжилгээнд 12 цаг зайлшгүй өлөн байх шаардлагатай.

- 6.2. Шээсний шинжилгээнд бэлтгэх:
 - 6.2.1. Биеийн хүчний хөдөлмөр эрхэлдэг, биеийн тамир спортоор хичээллэдэг хүмүүс шинжилгээ өгөхөөс 3 хоногийн өмнөөс хүчний дасгал хийгээгүй байх;
 - 6.2.2. Шээсний шинжилгээ өгөхийн урд өдөр улаан манжин зэрэг шээсний өнгөнд нөлөөлдөг хүнсний бүтээгдэхүүн болон шоколад, кофе зэрэг хэт чихэрлэг зүйлийг хэрэглээгүй байх;
 - 6.2.3. Шинжилгээг заавал зориулалтын нэг удаагийн ариун саванд авах;
 - 6.2.4. Зарим эм нь шээсний өнгөнд нөлөөлдөг тул ямар нэг эм хэрэглэж байгаа эсэхийг эмнэлгийн ажилтанд мэдээлэх;
 - 6.2.5. Өлөн шээснээс шинжилгээ авах ба түүний дунд гуравны нэгээс таслан авах;
 - 6.2.6. Сарын тэмдэг ирэх гэж буй болон ирсэн, дөнгөж дуусч байгаа тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэнд мэдэгдэх, шаардлагатай бол шинжилгээ өгөхийг тодорхой хугацаагаар хойшлуулах;
 - 6.2.7. Шээсийг сайн таглан сэгсрэлгүй 1-2 цагийн дотор лабораторид шинжлүүлнэ.

- 6.3. Зүрхний цахилгаан бичлэг хийлгэхэд бэлтгэх:
 - 6.3.1. Гар утсаа унтраасан байх;
 - 6.3.2. Металл зүйлүүд болох цаг, бугуйвч, ээмэг, бөгж зүүгээгүй байх;
 - 6.3.3. Зүрхний бичлэг хийлгэхээс 2 цагийн өмнө хооллох;
 - 6.3.4. Зүрх дэлсэлтийг нэмэгдүүлдэг бүтээгдэхүүн хэрэглээгүй байна /энергийн ундаа, кофе, архи гэх мэт/.

- 6.4. Хэвлийн хэт авиан оношилгоо хийлгэхэд бэлтгэх:
 - 6.4.1. Өлөн үед эсвэл хооллосноос хойш 6-8 цагийн дараа шинжилгээг хийлгэх;
 - 6.4.2. Давсаг шээстэй байх;
 - 6.4.3. Илүүдэл жинтэй, гэдэс дүүрдэг хүмүүс 3 хоногийн өмнөөс хий үүсгэдэг хоол хүнс хэрэглээгүй байх /сүү, цагаан идээ, хийжүүлсэн ундаа, өндөг/;
 - 6.4.4. Шинжилгээнд хамрагдахаар ирэхдээ биед эвтэйхэн хувцасласан байна.

